



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 4/15

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Татвар төлөгчийн бүртгэлийн ажлыг сайжруулах талаар хийх ажлын төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилийг хангах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч (Д.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга (Ц.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭРДЭНЭСУВД



621001029

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн  
даргын 2022 оны 28 сарын 29-ны өдрийн  
115 дүгээр тушаалын хавсралт

УИЦА9858  
1115128578  
90-44027

**2022 ОНД ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛИЙН АЖЛЫГ  
САЙЖРУУЛАХ ТАЛААР ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	Татварын тайлангаа 8 улирал дараалан Х тайлан гаргасан, үйл ажиллагаа явуулаагүй ААН-ийн судалгааг сумд болон байцаагчдаас гаргуулан авч татан буулгах саналыг ТТҮГ-т хүргүүлэх.	2022.03.30	Д.Болор-Эрдэнэ /ААН хариуцсан байцаагч, сумдын байцаагчид/
2	Дээрхи хуулийн этгээдүүдийг татан буулгах саналыг ТТҮГ-т хүргүүлэх.	2022.03 сард	Д.Болор-Эрдэнэ /Нэгтгэл хийж ТТҮГ-т хүргүүлэх/
3	МТТАТ-ын төрлийн бүртгэл Баян-өндөр суман дээр давхар бүртгэгдсэн 18 сумдын бүртгэлийг хасаж, цэгцлэх. /Нэг суманд 800-900 иргэн давхар бүртгэгдсэн байна/.	2022.03.04	Д.Болор-эрдэнэ
4	Хуулийн этгээдийн удирдлага солигдсон, холбогдох дугаар, бүртгэлдээ оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагатай нийлж, бүртгэлийг тухай бүр нь шинэчлэх.	Жилдээ	Д.Болор-Эрдэнэ
5	Улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн, бүртгүүлэхээр хүлээгдэж байгаа төлөвтэй хуулийн этгээдийг хугацаанд нь бүртгэх.	Тухай бүр	Д.Болор-Эрдэнэ
6	Хуулийн этгээдийн бүртгэлээс хасагдсан, татварын албанд бүртгэлтэй, тооцооллын үлдэгдэлтэйн улмаас хасагдахгүй байгаа 6 хуулийн этгээдийн илүү дутуу үлдэгдлийг шийдвэрлүүлж, бүртгэлээс хасч цэгцлэх.	Эхний хагас жилд	Д.Болор-Эрдэнэ
7	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, шинээр бий болсон хөрөнгийг бүртгэн татварын бааз суурийг нэмэгдүүлэх.	жилдээ	М.Бямбасүрэн Бүх байцаагч
8	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг цэгцлэх, /Хасагдсан тээврийн хэрэгслийн судалгааг Авто тээврийн төвтэй нийлж, ашиглагдахгүй болсон тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах/.	Эхний хагас жилд	Б.Дорждулам
9	Галт зэвсэг эзэмшигчийн бүртгэлийг Цагдаагийн байгууллагын бүртгэлтэй таарч	2022.06.30, 2022.12.01	Б.Батдолгор

	байгаа эсэх талаар сум тус бүртэй нийлж, бүртгэлд байхгүй татвар төлөгчийг нэмж бүртгэх.	-ны дотор	
11	Борлуулалтын орлого нь 50,0 саяаас дээш орлоготой иргэн, ААН-ийг НӨАТ төлөгчөөр хугацаанд нь бүртгэж, татвар төлөгчийг эрсдэлээс хамгаалах.	Тухай бүр нь	Я.Наранчимэг
12	Татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн алдаа, зөрүүтэй бүртгэгдсэнийг тухай бүр нь засварлуулах.	Жилдээ	Бүх байцаагч
13	Төлөвлөгөөний явцын байдлыг сар бүр гаргаж хэлтсийн даргад танилцуулах.	Сар бүр	Д.Болор-Эрдэнэ

---oOo---